



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/413

Алтай хот


Цэргийн дүйцүүлэх албанаас
хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолын 5.3, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн дүйцүүлэх албанд 2019 онд элсэн орж алба хаах хугацаандаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр заасан газарт ирээгүй, оногдуулсан үүргийг биелүүлэхээс зайлсхийж, цэргийн штабтай байгуулсан гэрээ болон дүйцүүлэх албаны журмыг удаа дараа зөрчсөн Наранцэцэгийн Сумъяабазар, Пүрэвдоржийн Гантогтох, Хадбаатарын Шагай, Батхуягийн Батсайхан, Эрдэнэцогтын Дамдинбазар, Цогтын Буян-Өлзий нарыг 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс гэрээг цуцлан цэргийн дүйцүүлэх албанаас хассугай.

2.Цэргийн дүйцүүлэх албанаас хасагдсан иргэдтэй тооцоог хийж захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг цэргийн штаб (хурандаа Д.Төмөрбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР